

Усны тухай

Надад яръж өгөөч



Усны тухай

Надад яръж өгөөч

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага –ЮНЕСКО-гоос эрхлэн гаргасан “Далайн тухай надад ярьж өгөөч” номноос сэдэвлэн Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын нэмэн засварласан хэвлэл. Энэхүү хэвлэлд ашигласан дизайн, мэдээ мэдээлэл нь аль нэг улс гүрэн, газар нутаг, хот, засаг захиргааны эрхзүйн статусын талаар ЮНЕСКО, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) болон өөр ямарваа этгээдийн үзэл баримтлалыг тусгаагүй болно.

© ЮНЕСКО 2003; Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2009 текст ба гэрэл зураг
© Ноэ Эдишнсийн Новел Арш 2003, хэвлэлийн дизайн

ISBN ЮНЕСКО 92-3-203872-2
ISBN Ноэ Эдишнсийн Новел Арш: 2-84368-046-8

Зургийг: Паскаль Колландже

Дизайныг: Франк Турнэл

Хэвлэлийг: Турийн дахь Аж Арти Графиш

Дэлхийн бүх улс оронд зохиогчийн бүхий л эрхээр хамгаалагдсан болно.

ЮНЕСКО ба Ноэ Эдишнсийн Новел Аршын зөвшөөрөлгүй бүрэн эхээр нь эсвэл хэсэгчлэн хэвлэн нийтлэх, олшуулан түгээх, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

www.unesco.org/publishing

Франц хэлнээс хөрвүүлсэн: Э. Солонго

Хянан тохиолдуулсан: Е.Батчулуун, Н. Мандах

Хэвлэлийн эхийг: Ж. Даваадорж

Адмон хэвлэлийн компанийд хэвлэв.

Усны тухай

Надад яръж өгөөч



Оришил

Ус бол зөвхөн манай дэлхий дээр л оршдог амьдралд хамгийн их үүрэг гүйцэтгэдэг бодис. Усгүйгээр дэлхий, хүн төрөлхтөн ямар байх байсан биз ээ. Уснаас уур амьсгал, хүрээлэн буй орчин, бидний амьдрал төдийгүй аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүхий л салбар хамаарч байдаг. Ус хөдөө аж ахуйн хамгийн гол хэрэглээ болохоос гадна, гол мөрөн, далайн татралт түрэлт, халуун булаг, рашаан нь эрчим хүчний эх үүсвэр болдог Энэ мэтчилэн усны ач холбогдол, гүйцэтгэх үүргийн талаар тоочоод баршгүй.

Үүлс нүүж, манан татах, борооны дараах солонго гэхчлэн бидний сэтгэлийг ариусган, нүдийг баясгадаг байгалийн олон үзэгдлүүд ч устай холбоотой байдгийг бодоход ус зөвхөн амьдралын эх сурвалж төдий биш юм.

Харамсалтай нь өнөөдөр усыг хэт их ашиглан, бохирдуулж байгаагаас усны нөөц хомсдох болсон нь хүн төрөлхтнийг түгшээж байна. Усыг ариг гамттай ашиглах нь шинжслэх ухаан, техникийн салбарт төдийгүй, хүн бүр, үйл хөдлөл болгондоо анхаарах асуудлын нэг болж байна. Өнөөдөр бид усыг хэрхэн зөв ашиглаж, хамгаалж чадна, бидний хойч үеийнхний амьдралын баталгаа төдий чинээ сайн байх болно.

Энэхүү номонд бид усны тухай, түүний физик, химиин шинж чанар, усны нөөц болон устай холбоотой байгалийн зарим үзэгдлүүдийн талаар та бүхэнд толилуулж байна.

Усны шинж чанар

Устэрөгчийн исэл болох ус нь өнгө, үнэр, амтгүй, тунгалаг химийн энгийн нэгдэл боловч олон онцлог шинжтэй. Эдгээрээс дурдья.

Та үүнийг мэдэх үү?

Усны найрлагад D_2O буюу хүнд ус, T_2O буюу маш хүнд ус мөн бага хэмжээгээр байдаг. Хүнд усанд энгийн устэрөгчийн (H) оронд түүний хүнд изотоп болох дейтерий, харин маш хүнд усанд тритий ордог байна. Усанд агуулагдах хүнд ус халуун бүсийн далай, тэнгист илүү байдаг ба давсжилт 10 хувиар бага байдаг.

- Ус ердийн нөхцөлд нэгэн зэрэг хатуу (мөс), шингэн (ус), хий (усны уур) гэсэн гурван төлөвт оршиж чаддаг цорын ганц бодис. Тухайлбал, өвлийн цагт тасалгааны цонхон дээр цан тогтсон байх нь олонтаа. Энэ нь усны хатуу хэлбэр. Тасалгаан дахь агаарт усны уур агуулагдана. Хэрэв аяганд ус хийж тавивал бид усны гурван төлвийг зэрэг харж байгаа нь тэр юм.
- Цэнгэг ус $4^{\circ}C$ температуртай үедээ хамгийн их нягтай байдаг. Температур нь үүнээс буурах буюу нэмэгдэхэд усны нягт багасна. Энэ шинж чанар нь усны гадаргаас ёроолын хооронд босоо хөдөлгөөн явагдаж, тэжээлийн бодисууд болон хүчилтөрөгч зөөгдөх шалтгаан болно. Мөн энэ шинжийнхээ ачаар ус хөлдөх үедээ нягт нь багасаж эзлэхүүн нь тэлдэг. Шилэнд хийсэн ус хөлдөхөд шил нь хагардаг шүү дээ. Үүний нэгэн адил жижиг горхи ч өвлийн цагт хөлдөхдөө өргөн гол шиг болдог. Нягт багатай тул мөс усны гадарга дээр л бүрхэн тогтож, мөснөөс доошихи усны амьдрал өвлийн улиралд “хамгаалагдана.”
- Ус дулаан багтаамж сайтай тул халж, хөрөх нь удаан. Түүний энэхүү шинж чанар уур амьсгалын горимд ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Тодруулбал, зуны цагт далай, тэнгисийн усанд асар их хэмжээгээр хуримтлагдсан дулаан нь өвлийн улиралд уур амьсгалыг зөөлрүүлэхэд зарцуулагдана. Ийм ч учраас далай тэнгистэй ойр орших нутагт уур амьсгал зөөлөн байхад далайгаас алслагдсан манай орон шиг газар эх газрын эрс тэс уур амьсгал бүрэлддэг. Ганц жишээ дурдахад Францын Парис ба Улаанбаатар хотын орших өргөрөг бараг адилхан, хойд өргөргийн 48° -д оршдог, жилийн турш өдөр шөнийн үргэлжлэх хугацаа, нарнаас ирэх цацрагийн хэмжээ адил боловч уур амьсгалын хувьд эрс ялгаатайг бид мэднэ. Энэ нь чухам дээр дурдсан далай тэнгисийн нөлөө юм. Далайгаас алс орших Ази тивийн төв хэсэг

дэлхий дээр хамгийн эрс тэс уур амьсгалтай болсны учир нь энэ ажээ.

- Усны гэрэл шингээх, ойлгох шинж чанар өвөрмөц.



Өнгөгүй тунгалаг учир усанд хэт ягаан туяа ихээр шингэнэ. Нарны цацраг далай тэнгисийн усанд дөнгөж 100-400 м гүнд л нэвтрэх бөгөөд дээд хэсэгт нь хэт ягаан, түүнээс дооших давхаргад улаан, шар болон цэнхэр ногоон туяа шингэнэ. Энэ нь усны давхаргын няйт, даралт, температур өөр өөр байдгаас шалтгаалж байгаа юм.

- Цэнхэр өнгийн туяа долгионы уртаар хамгийн богино тул усанд ихээр сарниж, далай, тэнгис, гол мөрний ус цэнхэртэн харагддаг. Гэвч нарны гэрэл нэвтрэх гүнээс доош усны өнгө өөрчлөгдөн бүр гүндээ хар өнгөтэй. Иймээс далайн гүнд сохор амьтан олон. Мөн бохирдсоноос болж усны өнгө өөрчлөгддөг.
- Нарны цацраг усны зөвхөн гадаргын 100 м орчим гүнд шингэх боловч 600-700 м хүртэл гүнд тархан сарнина. Хэрэв нар эгц тусаж байгаа бол цацрагийн ихэнх нь усанд шингэж дөнгөж 5% нь л усны гадаргаас эргэж ойно. Харин цасны гадарга дээр ирж буй цацрагийн 85 хувь нь эргэж ойдог бол мөсний завсраар далайн усанд нарны цацрагийн дөнгөж 2 хувь нь шингэдэг байна. Гадаргын энэхүү ойлгох чадварыг альбедо хэмээн нэрлэнэ. Ингэхлээр шинэ орсон цасны альбедо хамгийн өндөр, усны альбедо бага байна. Энэ нь уур амьсгалд чухал үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь: манай орны хувьд III ба IX сард (хавар, намар) нарнаас ирэх цацрагийн

Та үүнийг мэдэх үү?

Дэлхийн хамгийн тунгалаг устайд тооцогдо Саргасын тэнгист цагаан өнгөтэй объект 66,5 м гүнээс харагддаг ба үзэгдэх орчин нь бараг 100 м хүрнэ.

Та үүнийг мэдэх үү?

Хэрэв бид 18
мянган жилийн
тэртээ амьдрарч
байсан бол

Англиас
Европ хүртэл,
Ази тивээс
Аляск хүртэл
хуурай газраар
аялах байсан
билээ. Учир
нь сүүлчийн
мөстлөг
дэлхийн хойд
хагасад өргөн
уудам талбай
хамарч байв.

Мөс ихтэй
болооор
далай
тэнгисийн
усны төвшин ч
өнөөгийнхээс
хавьгүй бага
байжээ.

хэмжээ адилхан атал цас ихтэй хаврын цагт цацрагийн
ихэнх нь ойсноос цаг агаар сэргүүн байdag билээ.

- Ус нэг төлвөөс нөгөөд шилжихдээ дулааныг ялгаруулах
буюу зарцуулна. Энэ нь мөн л усны өвөрмөц онцлог
юм. Ус ууршин уур болоход дулаан зарцуулагддаг бол
уур эргээд шингэн болох явцад дулаан ялгарна. Жишээ
нь, шүүдэр ба манан үүсэх нь усны уур шингэн төлөвд
шилжиж буй хэлбэр юм. Энэ үед дулаан ялгарч хөрсний
давхаргыг хөлдөхөөс хамгаалж байdag.
- Ус нь цахилгаан харилцан үйлчлэлийг сулруулах ба
цэнгэг усны хувьд далай тэнгисийн уснаас 1000 дахин
бага. Энэ нь далай тэнгисийн усанд ууссан давс нь
цэнэгт ион үүсгэдэгтэй холбоотой юм.

Энэ мэт ус олон шинж чанараар дэлхий дээр орших
бусад бодисоос ялгаатай, тэр хэмжээгээр ч амьдрал, уур
амьсгалд нөлөөтэй тул усыг чандмань эрдэнэ хэмээн
дээдлэх нь аргагүй билээ.

Цэнхэр нүдэн гариг

Дэлхийг сансраас харвал цэнхэр өнгөтэй үзэгддэг аж.
Учир нь дэлхийн гадаргын 2/3 буюу 361 сая км талбай
нь далай тэнгисээр бүрхэгдэнэ. Нуур гол мөрөн, мөстлөг
мөсөн гол гүний ус нь хуурай газрын усны төрөл болно.
Газрын гүнд дэлхийн бүх гол мөрөн нуураас олон дахин
илүү их ус оршино. Түүнчлэн агаар мандалд нэгэн зэрэг
13-15 сая шоо км ус агуулагдана. Устай байдаг нь нарны
аймгийн бусад гаригуудаас манай дэлхийн ялгагдах гол
онцлог юм.

Усыг магмаас үүсэлтэй гэж үздэг. Дэлхий үүсэж байсан
4.5 тэрбум жилийн тэртээ галт уулын идэвхжил их, дэлхийн
гүнээс магма бялхаж байв. Энэхүү магмад агуулагдаж
байсан усны уур нь дэлхий хөрөх үед өтгөрөн шингэн
төлөвд шилжиж усан мандлыг үүсгэсэн гэж эрдэмтэд
үздэг. Одоо ч галт уулын дэлбэрэлтээр бялхах магмын
найрагад усны уур агуулагдсан байдаг нь үүний гэрч юм.

Дэлхий дээрх усны нөөцийг эрдэмтэд 1.5 сая шоо км хэмээн тодорхойлжээ. Гэвч үүнээс хүн төрөлхтөн ашиглах боломжтой хэсэг нь тун өчүүхэн юм. Зүйрлэвэс, дэлхийн бүх усыг 100 литр хэмээн үзвэл бидэнд ердөө л ганц жижиг халбага ус л ашиглагдаж байгаа болно.


Ус байнгын эргэлтэнд оршдог. Далай тэнгис, гол мөрөн, нуур ба хуурай газрын гадаргаас ус ууршин уур болон дэгдэж агаар мандалд гарна. Өндөрт гарсан усны уур өтгөрч үүл үүсдэг. Үүлэн дэх усан дусал ба мөсөн талстууд хоорондоо нэгдэн нийлж томорсоор хур тунадас болон газар бууна. Бороо, цасны ус нь гол мөрнөөр дамжих юмуу эсвэл газрын хөрсөнд шингэн нэвчих замаар далай тэнгист дахин нийлнэ. Уүнийг *байгаль дахь усны эргэлт* гэж нэрлэх бөгөөд энэ нь тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Энэхүү эргэлтийн явцад ус нэг төлвөөс нөгөө төлөвд шилжин, байгалийн олон үйл явцад оролцно. Эргэлтийн ачаар дэлхий дээрх усны тэнцвэрт байдал хадгалагдаж байдаг байна.



Харин байнга хүйтэн байдаг өндөр уулын орой болон туйл орчмын нутгуудад орсон цас хайлахгүй дарагдан няягтарсаар мөс болон хувирч он удаан жил хадгалагдан үлдэнэ. Жишээ нь: дэлхийн өмнөд тул орчим - Антарктидэд мөсний зузаан 4000 м хүрнэ. Мөсний гадаргаас ч ууршилт явагдаж агаарт дэгдэнэ. Ус далай тэнгис хуурай газар, мөсний гадаргаас энэ л замаар дахин ууршиж бороо тунадас болон орж гол мөрөнг тэжээнэ. Энэ бол усны дуслын мөнхөд орших аялал юм.

Дэлхийн нийт усыг бүхэлд нь **усан мандал** хэмээн нэрлэнэ. Усан мандлын 97,5 хувийг далай тэнгис эзлэх ба үлдэж буй 2,5 хувь нь хуурай газрын буюу цэнгэг ус юм. Цэнгэг усны ихэнх (67,8%) нь цас мөс хэлбэрээр орших ба газар доорх ус 30.1 хувийг эзэлнэ. Ингээд үлдэж буй өчүүхэн бага хэмжээ нь л гол мөрөн, нуур, хөрсний чийг гэхчлэн бидэнд хүртээлтэй ус юм. Ингэхлээр үнэн хэрэгтээ дэлхий усаар тийм ч баян биш юм. Усыг гамнаж, хамгаалахын учир чухам үүнд оршино.

Усан мандлын бүрэлдэхүүн



Усан мандлын зарим бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар товч дурдъя.

Далай тэнгис

Далайн ус тасралтгүй үргэлжлэх бөгөөд газарзүйн байрлалаар нь *Энэтхэгийн, Номхон, Атлантын болон Хойд мөсөн далай* хэмээн нэрлэдэг. Австрали зэрэг зарим оронд Өмнөд далай хэмээн ялгах нь ч бий. Номхон далай аль ч үзүүлэлтээр хамгийн том нь бөгөөд бусад бүх далайн талбайг нийлүүсний тэн хагастай тэнцэх өргөн уудам орон зайд эзэлнэ. Түүний дараа Атлантын далай, Энэтхэгийн далай тус тус орно. Битүү мөсөөр хучигдсан Хойд мөсөн далай талбайгаар бага хэдий ч олон шинж чанарыг нь харгалзан тусад нь далай болгон авч үздэг. Тэнгис гэдэг нь далайн усны хэсэг боловч эх газар луугаа түрж орсон тул далайн үндсэн хэсгээсээ усны шинж чанар нь ялгаатай. Тэнгисийг захын ба газар дундын хэмээн ангилна. Эх газрын захаар орших тэнгисийг бодвол эх газруудын дунд орших тэнгисийн усны шинж чанар нь далайн уснаасаа нэлээд өөрчлөгддөг. Жишээ нь: Евроази ба Африкийн эх газрын хооронд орших Газар дундын тэнгис зөвхөн Гибралтарын хоолойгоор л Атлантын далайтай холбогддог бол Азийн зүүн хэсгээр орших Шар тэнгис, Евроазийн эх газрын хойд захаар хүрээлэх Хойд Мөсөн далайн тэнгисүүд нь задгай буюу захын тэнгист тооцогдоно.


Далайн ёроолын гадарга тэгш бус, өндөр уул нурууд, өргөн тал, хөндий, гүн хонхор гээд яг л хуурай газрын гадаргатай адил юм.


Далайн ёроолоор тасралтгүй үргэлжлэх уул нуруудыг *далайн гол нурууд* хэмээн нэрлэнэ. Эдгээрийн нийт урт нь д 60000 км хүрэх ба энэ нь манай дэлхийн хамгийн том, хамгийн урт үргэлжилсэн уулсын систем юм. Гол нуруудын зарим хэсэг усны гадарга ил гарах бөгөөд энэ нь арал юм. Дэлхий газрын зураг

Та үүнийг
мэдэх үү?

Далайн урсгал нь дэлхийн хойд хагаст нар зөв буюу цагийн зүүний дагуу, дэлхийн өмнөд хагаст нар буруу буюу цагийн зүүний эсрэг чиглэсэн битүү цагираг үүсгэдэг. Энэ нь дэлхийн эргэлтээс үүсэх даялагч хүчий нөлөө юм.







Та үүнийг мэдэх үү?

Дэлхийн хамгийн том, ус ихтэй гол болох Амазонк мөрний ай сав 3 сая км кв бөгөөд энэ нь манай орны нутаг дэвсгэрээс 2 дахин их юм. Харин хамгийн уртад тооцогдох Нил мөрөн Африкийн төв хэсгээс Сахарын цэлийг туулан Газар дундын тэнгист цутгагдаг. Түүний урт нь 6695 м ажээ. Монголын хамгийн урт гол нь Сэлэнгэ мөрөн юм.

ажиглавал далайн энэхүү нуруудын дагуух хэсэг цайвар өнгөөр дүрслэгдсэн байгаа. Исландын арлаас эхлэн үргэлжлэх Атлантын далайн гол нурууны дагуу Азорын, Канаарын, Фолклендын гэх мэт арлууд оршиж байгааг зураг дээр харж болно. Түүнчлэн далайн ёроолд өргөн тал, хөндий, гүн хонхор, ховил ч олон. Гүн хонхорууд нь далайн түвшнээс доош 6000-11000 м хүрнэ. Далайн хамгийн гүн болох Марианы хонхор нь 11034 м бөгөөд дэлхийн гадаргын хамгийн нам цэг юм.

Далайн гол нуруудын хяр дагуу галт уул олон, газар хөдлөлт ч их. Үүний улмаас дэлхийн гүнээс magma бялхаж, далайн ёроол шинээр “үүсэж” байдаг. Далайн ус байнгын хөдөлгөөнд оршиж, урсгал давалгаанд эргийн хэлбэр нь өөрчлөгдөн, угаагдаж элэгдсэн хурдас чулуулаг далайн ёроолд хуримтлагдаа байдаг.

Гол мөрөн

Дэлхийн эртний соёл иргэншил, анхны хотууд аль нэгэн том голын хөндий, эсвэл нуурын эрэг орчимд дүссэн байдаг. Өнөө ч том хотуудын байршил гол, усыг “бараадсан” байдаг билээ. Тухайлбал, Эртний Хархорин Орхоны хөндийд үссэн бол, Улаанбаатар хот Туулын хөндийд босжээ. Сөүл хотын дундуур Хан мөрөн, Парисын дундуур Сена, Лондон хотын Темза гээд л тоочих жишээ олон. Учир нь гол мөрөн нур бол цэнгэг усны үндсэн хэсэг, хүн төрөлхтөнийг тэжээгч юм. Цэцгийн мандлаас эхлээд тариалангийн талбайд гол, нуурын усыг л ашигладаг. Гадаргын ус багатай тул эргэн тойрон далайгаар хүрээлэгдсэн ч Австрали тивд усны хомсдол маш хурцдаж



Түүл голын хөндий



Голын усны бохирдол

байгаагийн учир ч үүнтэй холбоотой. Хэдийгээр дэлхийд Миссисипи, Амазонк, Дунай гэхчлэн том гол мөрөн олон ч усны нийт хэмжээ нь усан мандлын дөнгөж 0,0001 (цэнгэг усны 1.3%) хувь болдог.

Гол бол газрын гадаргын өндөрлөг хэсгээс нам газар луу голдрил даган урсах байнгын урсац юм. Голын ус нь хур тунадас, газрын доорхи ус, зарим тохиолдолд мөнх цас, мөсөн голын хайлсан усаар тэжээгдэж байдаг.

Зарим жижиг гол хөрсөнд шингэн замхардаг бол ихэнх нь өөр том гол мөрөн, нуурт, эсвэл дамжин урssaар бүр далай тэнгист цутгадаг. Энэ байдлаар нь Номхон далайн, Хойд мөсөн далайн, Атлантын далайн, Энэтхэгийн далайн болон Гадагш ургалгүй ай савын гол хэмээн ангилдаг.

Манай орны гол мөрд Номхон далайн, Хойд мөсөн далайн болон Төв Азийн гадагш ургалгүй ай савд багтах бөгөөд ихэнхийг Хойд мөсөн далайн ай сав эзэлнэ. Тухайлбал, Туул, Орхон Сэлэнгэ зэрэг томоохон гол мөрдийн ус Байгаль нуураар дамжин Хойд мөсөн далайд хурдэг бол зүүн зүг урсах Онон, Хэрлэн гол Номхон далайд усaa өгнө. Харин Ховд, Буянт, Завхан зэрэг гол гадагш ургалгүй ай савд багтана. Хэдийгээр манайд ийм олон гол мөрөн байгаа мэт боловч үнэн хэрэгтээ монгол орон усны нөөцөөр тийм ч баялаг биш юм. Нэгж талбайд ногдох гадаргын усаар дэлхийн дунджаас хол хоцордог нь үүний жишээ юм. Гэвч голын эх, сав дагуух модыг огтлох, алт угаах зэрэг олон шалтгаанаар голын ус бохирдон татарч, зарим нь бүр ширгэн алга болж буй тохиолдол олширсоор байгаа нь харамсалтай. Тоо баримтаас үзэхэд сүүлийн хэдхэн жилийн дотор 600 гаруй гол горхи ширгэн алга болжээ. Үүний нэг нь Онги гол юм.

Иймд гол мөрдийг бохирдуулахгүй байхад хүн бүрийн оролцоо чухал.

Нуур

Нуур нь газрын хонхор хотост хуримтлагдан тогтсон ус боловч жирийн усан сангаас ялгаатай нь нуур бол амьд ертөнц юм. Нуурын усанд элдэв төрлийн тэжээлийн бодис, хүчилтөрөгч зэрэг хий уусаж амьд биетийн амьдралын орчин болж өгдөг. Түүнчлэн нууранд явагдах хими, биологийн олон үйл явц нь усны амьд биет, загас, сээр нуруугүйтний амьдралд чухал үүрэг гүйцэтгэнэ. Голын усаар зөөгдөж ирсэн эрдэс чулуулаг нуурын усанд задарч шингэхээс гадна ёроолд нь тунан зузаан давхарга үүсгэнэ. Энэ нь мөн л тэжээлийн орчин болно.

Том нуур бол орчныхоо уур амьсгалд ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Усанд нь хуримтлагдах дулаан орчмынхоо уур амьсгалыг чийгшүүлэх, зөвлрүүлэх зэргээр нөлөөлнө.

Нуурууд олон янз. Гарал үүслээр нь тектоникийн, мөстлөгийн, голын, тэнгисийн, галт уулын, хиймэл гэхчлэн ялгагдахаас гадна усны балансаар нь гадагш урсгалтай болон гадагш урсгалгүй хэмээн ангилна. Мөн усны химийн найрлагаар нь цэнгэг, эрдэст буюу давстай, шорвог нуур хэмээн ялгадаг. Шорвог нуураас давс олборлоно. Жишээ нь: манай Сангийн далай нуураас давс олборлодог.



Үүсв. нуур

Судалгаа шинжилгээ

ЮНЕСКО-гийн Олон Улсын Усзүйн Хөтөлбөр (ОУУХ) нь усны талаарх судалгаа, шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах, мэргэжилтний чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдагаараа НҮБ-ын хүрээнд ч чухалд тооцогддог.

1996 онд болсон Ус ба Байгаль орчны олон улсын бага хурлаас ОУУХ-ийг байгуулан, усзүйн үзэгдлүүд ба биологийн үйл явцын харилсан хамаарлыг нэгтгэн авч үзэх судалгааны ажлыг тодорхой сав газрын хэмжээнд хэрэгжүүлж эхэлжээ. Энэ нь цэвэр усны нөөцийг ашиглах, хамгаалах нэгдсэн менежментийг бүрдүүлэх шинэ үзэл баримтлал, эдийн застийн хэмнэлттэй арга технологийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн юм.



"Дулаан бүсийн далай ба агаар мандал"
(TOGA) хөтөлбөр

Эль-Ниньо хэмээх байгалийн үзэгслийн үчир шалтгааныг "Дулаан бүсийн далай ба агаар мандал" хөтөлбөрийн хүрээнд судалж олон чухал үр дүнд хүрнээ. Энэ хөтөлбөрийг олон үлсдэг TOGA (Tropical Ocean Global Atmosphere) хөтөлбөр хэмээн тэрлэдэг. Энэхүү хөтөлбөрт нэгдэн үйл ажиллагааг нь дэмждэг бүх үлс орон цөлжилтийн бодит сорөг нөлөөллийг бүүрүүлах, газар тариаланг нүүрлэж буй үер, усны хэрэглээ, засасны алж ахуйн менежментийн түхай болон агаар манделын төлөв байдлын талаарх бусад мэдээллээр хангаждаг. Уз хөтөлбөрийн хүрээнд Эль Ниньо-ийн ишвихижлийг жилийн өмнөөс үрьднилан тооцоолох программыг бүтээсэн нь ихээхэн аж холбогдолтой болсон билээ.

Цаг агаарын
үрьднилсан

мэдээг үнэн зөв
боловсруулахын
тулг судалгааны
хөлөг онгоц,
ажилладаг.

Хөлөг онгоцноогоо
амьдралт үрсгалас
үрсгалд шилжкин
аялж, далайн
задарга ба үүнд
өөрөр түүмжин
ажиллалт

судалгаа хийдэг
мэргэжилтийнүүдийн
үүрэг нэн их.

Тэдний хүлээн
авсан мэдээг
сансралын холбоогоор
дамжуулсан
судалгааны төв
станци хүлээн авч
боловсруулалт
хийнэ.

Эль-Ниньо

Номхон далайн зүүн эрэг орчим Өмнөд Америкийн Перу ба Эквадорын эргийн дагуул их хэмжээний бороо орж, үер үс үүсэх үзэгслүүг Эль Ниньо зөврөз. Энэ нь 3-5 жилийн давтагдалтайгаар голилон Зүл сарын баярлан үеэр тохиолдолдог тул 19 дугаар зуунд үеэг Перүүүд “Есүсийн хүүхэд” засэн утгатай испаны үзеэр нарлажээ.

Пассат салхиний эри суларсан үеэг агаарын их, бага дараалтын мүжкээ ээлжлэн солигдсондоос болж Эль Ниньо үүснэ. Эль-Ниногийн үеэр циклонд барагтай бол автодазгүй Полелезийн аралд хүртэл хур түннэдээс элбэг ордог ажээ.

ОУУХ-ийн хэрэгжилтийн тав дахь үе шатны судалгаа нь усзүй ба экологийн хамаарлыг авч үзсэн юм. Ялангуяа “Хүн ба Шим Мандал” дэд хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн “Ландшафтын менежмент ба нөхөн сэргээлтэнд усны шилжилтийн бус буюу экотоны гүйцэтгэх үүрэг” төсөл ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. 2005 оноос Экологи усзүйн хөтөлбөр үс, усны нөөцтэй холбоотой байгаль орчны ба нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх төслүүдийг дэлхийн олон оронд хэрэгжүүлж эхэлжээ.

Номхон далайн зүүн хэсэгт орших хүүрэй үүр амьсгалтай бүсэд багтах Австрали тив “Эль Ниньо”-ийн нөлөөнд дор хүчинэй үер болон зан хүүрэйшилтийн сөрөг нөлөөнд өртөх болжээ.



УСНЫ АМЬТАН, УРГАМАЛ

* Усан орчны биологи

Далай тэнгис, гол мөрөн, нуур цөөрөм нь усны амьтдын амьдралын орчин болно. Усны амьтдыг төрөл бүрийн замаг, нялцгай биетэн, хавч хэлбэртэн, загас, халим гэхчлэн тоочивч баршгүй. Дэлхий дээр нийт 250000 гаруй төрөл, зүйлийн амьд организм бүртгэгдээд байгаагийн ихэнх нь далай тэнгисийн усны дээд хэсэгт оршино. Энэ нь усны гадаргаас доош хэдхэн зуун метрийн гүн хүртэлх нарны гэрэл нэвтрэх орон зай юм. Үүнээс доош харанхуй бас хүйтэн тул амьтад цөөн. Гэхдээ Далайн гүнээс хүйтэн ус түрж ирэх хэсэгт (*upwelling* үзэгдэл) амьдардаг амьтад ч бий.

Ийнхүү усан мандал нь өөрийн гэсэн амьтан, ургамал, бичил биетний төрөл зүйлээр баялаг бие даасан экосистем юм. Амьд организмууд нь усан орчинд явагдах химийн, биологийн бүхий л үйл явцыг зохицуулж усны чанарыг тогтвортой хэмжээнд байлгах үүргийг давхар гүйцэтгэнэ. Иймд усан орчин хүн төрөлхтний хүнсний үндсэн эх булгийн нэг болно. Далайн хөхтөн амьтад, загас, хавч, наймаалж зэргийг уснаас олборлоно. Ингэхлээр далай тэнгис, усны бусад нөөцийг хайрлан хамгаалах нь усны амьдралыг ч хамгаалж байгаа хэрэг юм.



Усан мандлын амьд организмыг:

Усны амьтан, ургамал, бичил биетнийг хэд хэд ангилна. Тухайлбал,

- **Ёроолынхон:** Далай тэнгисийн ёроолд гэрэлгүй бүсэд амьдардаг дун, хясаа, наймаалж, далайн зараа гэх мэт хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй амьтад орно.

- **Хөвмөл амьтад:** Эрэг ба ёроолоос хол, гэрэл сайн нэвтрэх бүсэд амьдрах бичил биетэн, замаг, хавч, нялцгай биетэн гэхчлэн олон төрөл бөгөөд ихэнх нь энгийн нүдэнд харагдахааргүй жижигхэн, том амьтдын гол хоол тэжээл болдог.

Ялангуяа дулаан ба хүйтэн ус холилдож буй заагт бүр их байна.

- **Цэнгэг усны амьтад:** Цэнгэг гол, нуурын олон төрөл, зүйл амьтад орно.

Усны амьтдын ихэнх масс нь далай тэнгист ногдоно. Энд аварга загас, далайн хав, халим, далайн гахай зэрэг том амьтадаас гадна нялцгай биетэн, хавч, элдэв төрлийн загас гэхчлэн тоо томшгүй олон төрөл, зүйлийн амьтан орно. Ялангуяа далайн дулаан ба хүйтэн урсгал нийлж буй зааг орчимд загасны үргжил маш сайн явагддаг тул загас агнуурын гол нутаг болно. Харин гол, нуурын усанд амьтдын төрөл, зүйл тоо цөөн. Учир нь энд далайн тэнгисийг бодвол биологийн төрөл зүйл нь харьцангуй хязгаарлагдмал экологийн нөхцөлд амьдардаг.

Усан мандлын биологийн төрөл зүйлийг өнөө хэр нь нарийвчлан тогтоогоогүй байна. 1992 онд баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын тухай” Конвенцийн нэг гол зорилт нь усан мандлын, тэр дундаа далайн төрөл зүйлсийг нарийвчлан тодорхойлж, судлах асуудал байсан билээ.

Та үүнийг мэдэх үү?

Махчин халим цаг гаруйхны хугацаанд 1500 метрийн гүнд шумбаж чаддаг байна.



Хамаасан загас, Португал үлс

Монгол орны гол мөрд, нууранд 64 уuguул зүйл загас байдгийн 48 нь Дэлхийн байгаль хамгаалах холбооноос гаргасан “Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуур” (IUCN, 2001)-ын дагуу бүс нутгийн түвшинд хамгааллын зэрэглэлд багтжээ. Гэвч эдгээрийн 23% нь устах аюул нүүрлэсэн буюу хорогдож (устаж байгаа, устаж

болзошгүй болон эмзэг гэсэн зэрэглэлд) байна хэмээн тодорхойлогдоод байна. Түүнчлэн дахин нэмж 6% нь цаашид ховордлын аль нэг зэрэгт ороход бэлэн байгаа буюу ховордож болзошгүй (ED) гэсэн жагсаалтанд оржээ.



* Экосистемийн ялгаа

Хуурай газрын ба усны экосистем нь түүний үндсэн хоёр төрөл бөгөөд дотроо олон янз. Тухайлбал, хуурай газрын экосистем нь уулын, ойн, хээрийн гэх зэрэг хуваагддаг бол усных нь далайн ба цэнгэг усны гэж ангилагдана. Далайн экосистемийг *шүрэн арлын*, *ёроолын* (2500 метрээс гүнд орших), *булангийн* гэх мэт олон төрөл болгож болохоос гадна эдгээр нь усны давхаргын гүнээс хамаарч амьтан ургамлын төрөл, бодис энергийн солилцоо нь өөр өөр байна. Хуурай газрын экосистемийг бодвол далайн амьд орчны судалгаа өнөөг хүртэл бүрэн тайлагдаагүй хэвээр байна.

Цэнгэг усны экосистемийг дотор нь *тогтоол усны буюу нуурын, урсгал усны буюу гол, горхийн, ус, чийгэрхэг газрын буюу намгийн хэмээн* ангилна. Эдгээр нь үүсэл хөгжлөөрөө эртний далайгаас гаралтай ч биологийн төрөл зүйлээр өөр хоорондоо эрс ялгаатай байдаг.

Хуурай газрын амьтдын нэгэн адил усны амьтад ч нүүдэллэж, шилжин суурьшдаг. Жишээ нь: халим зуны улиралд далайн дулаан хэсгээс арай сэрүүн хэсэг рүү нүүдэллэдэг байна.

Далай тэнгисийн экосистемээс эрдэс бодис, биологийн төрөл зүйлээр хамгийн баялаг нь эрэг хавийн бүс, шүрэн

Та үүнийг мэдэх үү?

Далайн хав
6.5 сая байсан
боловч эмх
замбараагүй
агнасны
улмаас 30
жилийн дотор
л устах аюулд
өртөж байна.

арлуудын болон ширэнгэн ойн (мод, бутны үндэс нь усанд тархан ургасан байдаг) экосистем юм. Харин хуурай газрын усны экосистемээс ус чийгтэй, намгархаг газруудад биологийн төрөл зүйл элбэг.

* Эрсдэлд орсон амьтан ургамлын төрөл зүйл

Эрдэмтдийн тооцоолсноор далайн 126 зүйлийн хөхтөн амьтдын 88 нь ховордож, устах аюулд өртөөд байна. Бусад төрөл зүйлийн хувьд ч энэ аюулын гадна үлдэж чадахааргүй байна.

Ийм нөхцөл байдал бий болсон нь хэд хэдэн шалтгаантай юм. Үүнд:

- *Хүн амын тоо асар хурдацтай өсөж байгаагаас үүдэн гарсан хэрэгцээний өсөлт:* Хүнсний хэрэгцээг хангахын тулд загасчлал нэмэгдэж улмаар зарим төрөл зүйлийг мөхөлд хүргэж байна. Тухайлбал 1970-аад онд Франц ба Испанийн далай тэнгисийн эрэг орчимд амьдарч байсан зоодой загас, Перугийн Аншуа хэмээх май загасны нэгэн төрөл бүрэн устжээ.
- *Гол мөрний бохирдол ихэссэн, голын голдрилыг өөрчлөх зэрэг хүний үйл ажиллагааны сөрөг үр дагавар:* Энэ шалтгааны улмаас нь экосистемийн нөөц баялаг хомсдон, зарим зүйл загас, бичил биетэн, сээр нуруугүйтэн устах аюулд өртөөд байна. Тухайлбал голын голдрилийг өөрчилснөөс яргай загас, могой загасны нүүдэл тасалдаж тооны өсөлт удааширагдаг ажээ. Ойрын нэгэн жишээ дурдахад, Туул голын голдрилыг өөрчлөн алт олборлох болсноор тэнд амьдардаг загасны төрөл зүйл 30 хувиар, байгалийн нөхөн үржил 50 хувиар тус тус буурчээ.
- *Хяналтгүй загасчлал ба ан агуурын төрөл зүйлийн хэт ашиглалт нь тоо толгой цөөтэй экологийн болон эдийн засгийн өндөр ач холбогдолтой төрөл зүйлсийг цөөрөхөд хүргэж байна.*
- 19 дүгээр зуунаас эхлэн халим агнах явдал эрс нэмэгджээ. Хэдийгээр олон улсын төвшинд халим загасыг хамгаалах гэрээ, хэлэлцээр олныг батлан хэрэгжүүлж байгаа ч хулгайн загасчлал буурахгүй хэвээр байна.

Үснэй биологийн үндсэн төрөл зүйл болох загасны хорогдлын гол шалтгаан нь асар хурдацтай нэмэгдэж буйз загас агнүүр, түүний дотор хүүль бусаар загаслах явдал юм. Монгол орни хувьсгүй энэ аюул нүүрлээг байна. Олон улсын худалдааны өсөлтийн түвшинээс хамааран загас агнүүрэг зохицуулж байх ёстой хэдий и зохицуулга и байхгүй байна. Манай орни хувьсгүй агнүүрэн тохиулахаа база, хулгайн агнүүрт ямар нэгэн сонголт байдаггүй, зөвхөн ашигийн хойноос л хөөмөлдөж буйг анхаарах ёстой. Загасны төрөл зүйл цөөрөхөд орон нутгийн хэрэглээ түнч очижихэн хувийг эзлэх бөгөөд агнасан загасны ихэнх нь Хятад, Оросын зах зээлд худалдаалагдаж байна.

Нэгэнтэй ховордож буй зүйл загасны хувьсгүй амьдрах орчин дороитох нь л "хангалийтай" аюулд хүргэдэг. Алт олборлолт зэрэг эдийн засгийн сонирхол татахаар газруудын гол, ус бохирдсноос загас хоол тэжээлээр дүнгэдэг, ондөгний хөгжил үргэлжилж байгаа. Мөнгөн ус, цианид ашиглан алт ялгах явцад гол, үсэнд органик бүс бохирдлын аюул нүүрлэдэг.

Манай орны цэнгэг үсны төрөл зүйлийн томоохон төлөөлөгч болох тул загасыг хяналтгүй агнах болсноор 1990-ээд оноос хойш тоо толгой нь эрс цөөрчээ.

НҮБ-ын "Биологийн төрөл зүйлийн тухай конвенц"-оор төрөл зүйлийн удмын санг хамгаалах, хадгалан үлдээх асуудлыг чухалд тавсан билээ.

Гэвч одоогоор хуурай газрын бадалайн биологийн төрөл зүйлийн харьцааг ч бүрэн гаргаагүй, далаин амьтан ургамлыг ч бүрэн тодорхойлоогүй байна.



Нийгмийн өсөн нэмэгдэж буй хэрэгзээг хангах биологийн төрөл зүйлийн хамгаалалтаяг зохицуулахын тулд ЮНЕСКО-гоос "Шим мандлын нөөц газар" хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд байгалийн үнаган дүр төрх, экосистем, биологийн болон генийн төрөл зүйлийг хадгалах үлдэхийн тулд нөөц газруудыг байгуулах, нийгмийн бүх хүрээг хамарсан, экологийг дээдэлсэн аж ахуйн хэлбэрийг хөгжжүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Дэлхийн 94 оронтой нийт 400 шим мандлын нөөц газар байгуулах боломжтой зэж тохиоолж байна. Тухалбал, 2000 онд 5-р сарын 5-нд Канадын Клайкуутын тохойд үсэн орчинд шим мандлын нөөц газрээг байгуулсан нь Канад дахь 8 нөөц газраас далаин орчинд хамрүүлсан анхны жишээ болжээ.

Манай Увс нүүр ба Хар Ус нүүр энэ хөтөлбөрт мөн багтажээ.



Далайд 100000 гаруй төрлийн нялцгай биетэн, 50000 төрлийн замаг, 25000 төрлийн загас, 5000 төрлийн далайн хөвөн болон 150 орчим хөхтөн амьтан амьдардаг

хэмээн бүртгэгдээд байна.



Франц улс 1972 оноос өөрийн харьялалд байдаг Газрын Дундад тэнгисийн хэсэгт маш богино хугацаанд тоо толгой нь хомсдсон далайн хавыг тусгай хамгаалалтанд авах шийдвэр гаргажээ. Гэвч амьдралын зүй тогтлын талаар мэдэхгүйгээс эрсдэл гарах нь олонтаа. Жишиг нь: эмэгчин далайн хав зулзагалах үедээ эрэг дээр гардаг боловч аялагч, амрагчид аюулгүй байдлаа бодож ус руу эргүүлэн шиддэг нь тэднийг үхэлд хүргэдэг.



Ширэнгэн ой ихтэй нутагт тариалангийн талбай болгохын тулд голын эргийн модыг огтлох нь амьтдыг тоо, толгой цөөрч, улмаар устах аюулд хүргэж байна.

Усан мандлын нөөц баялаг

Усан мандал биологийн арвин нөөцөөс гадна эрдэс баялаг, эрчим хүчний асар их нөөцийг агуулдаг. Эдгээрийг дурдья.

•Давс

Эрт дээр үеэс давсыг зөвхөн хүнсний зориулалтаар олборлож эхэлсэн боловч орчин үед химиин үйлдвэрийн чухал түүхий эд болжээ.

Хлор ба натрийн энгийн нэгдэл болох давс хэрхэн үүсдэг вэ? Хур тунадас, гол мөрний усанд угаагдсан уулын чулуулгийн найрлага дахь натрийн төрлийн элементүүд далай, тэнгисийн усан дахь магни болон хлортой нэгдэн “хлорт натри” гэх шинэ элемент үүсгэдэг нь давс юм.

Далайн дундаж давсжилт 35 промиль бөгөөд энэ нь 1 кг усанд 35 гр давс агуулагддаг гэсэн үг юм. Нуурын ус ч давстай байх нь олонтаа. Жишээ нь: манай Увс нуурын давсжилт 19 промиль хүрнэ. Дэлхий хэмжээнд олборлож буй давсны гуравны нэгийг далай тэнгисийн уснаас, бусдыг нь давстай нуур, эртний тэнгис, далай байсан хуурай газраас олборлодог байна. Ахн АНУ, Мексикийн хойг, Канад, Франц, Японд далайгаас давс олборлож эхэлжээ. Давс хамгийн их олборлодог газрууд нь Хар тэнгис, Газрын Дундад тэнгис болон Атлантын

урай, халуун юм. Бүр их олборлоно. Ты томоохон түрүн хотгор нуур, Сант,



Та үүнийг мэдэх үү?

Далайн усан дахь давсны нийт масс нь тэнд ууссан бүх хатуу бодисын нийлбэр жинтэй тэнцэнэ.

Андалан нүрүү үүсэх явцад хамигдсан тэнгисийн уснаас үрт удаан хугацааны түршиг үүршилт явагдсаар хүримтлагдан тогтсон давсны асар их нөөц, Боливид бий.

Та үүнийг мэдэх үү?

1 сая тонн
далайн усанд 5
кг алт, 250 кг
мөнгө, 500 кг
кобалт, 1000
кг титан, 2000
кг никель,
3000 кг уран,
зэс, этан болон
10000 кг цайр
агуулдаг.

Далайн ус болон
газрын хөрсон
дэх нүүрс-
устөрөгч (газрын
тос үүсгэгч
элемент)-овс
газрын тос
олборлох нь
ур амьсгалын
дулаарлын
нэг шалтгаан
хэмээн узэх
бolloо. Дэлхийн
хүн амын осолт
эрс нэмэгдэн,
түүний хэрээр
хэрэглээ ихсэж
буй өнөө үед
газрын тосны
олборлолтыг
бууруулна
гэдэг нь бараг
боломжгүй юм.

Буур, Холбоолж, Бор овоо, Сангийн далай, Гурван Тэсийн гүехэн нуурууд хамрагдана. Зарим үед геологийн өвөрмөц тогтоцын улмаас давсны томоохон нөөц хуримтлагдан тогтох нь ч бий. Үүний нэг нь манай Увс аймгийн нутагт байдаг Давсан уул юм.

* Эрдэс, ашигт малтмал

Далайн ёроолоос төмөрлөг ба олон металын нэгдлийг 50 жилийн өмнөөс л олборлож эхэлжээ. Энэ нь далайн нөөцийг ашиглах үндсэн чиглэлийн нэг болтлоо өргөжин хөгжиж байгаа боловч газрын хэвллийгээс олборлох нь илүү хялбар юм. Одоо далайгаас бром, магний илүү олборлож байна. Ялангуяа Мексикийн хойгт далайн давстай усны дээжээс магнийг ялган авдаг байна.

* Газрын тос ба байгалийн хий

Дэлхийн хэмжээнд ашиглаж буй газрын тос, байгалийн хийн багагүй хэсгийг далай тэнгисийн ёроолоос олборлодог. Энэ арга харьцангуй саяхан нээгдсэн төдийгүй хүнд техник хэрэгсэл хэрэглэдэг чамгүй өндөр өртөгтэй боловч маш эрчимтэй хөгжиж байна. Далайн усанд д агуулагдах газрын тосны нөөцийн гуравны хоёр хувь нь Персийн буланд байдаг бөгөөд “Ойрхи Дорнод” хэмээх энэ бүс нутаг газрын тосоор дэлхийд тэргүүлнэ. Одоогоор далай, тэнгисийн ёроолоос дэлхийн газрын тосны хэрэглээний 30%, байгалийн хийн 10%-ийг гарган авч байна.



* Цэнгэг ус

Далай тэнгис нь нэг талаар “цэнгэг усны нөөц” гэвэл та итгэх үү? Учир нь далайн ус давстай учир эрт дээр үеэс л далайчид ундгүй усгүй болсон тул сүйрдэг байсан тухай бид уншдаг. Гэтэл шинжлэх ухаан, техник хөгжсөн өнөө үед давс ялгах тусгай технологийн тусламжтайгаар далайн уснаас ундны цэвэр ус гаргаж авах боломжоотой болжээ. Энэ нь ундны усны хомдолд орсон зарим улс оронд усны хэрэгцээгээ хангах шинэ боломж олгож байна.

Далайн усыг давснаас нь ялгахад дараах хоёр үе шатыг дамждаг. Энэ нь:

1. Усыг халаан уурушулах замаар давсиг нь ялгах төхөөрөмжийг ашиглан далайн усыг нэрэх,
2. Маш нарийн мембран бүхий сувгаар усыг нэвтрүүлэх төхөөрөмжийг ашиглан нэрсэн усыг шүүх шат дамжлага болно.



Энэ шаталсан ўйл явцын үр дүнд далайн ус маш сайн цэвэршин хэрэглэх боломжтой болдог. Өнөөдөр нэрэх аргыг өргөн хэрэглэж байгаа ч шүүлтүүрийн арга нь арван тав орчим жилийн дараа илүү боловсронгуй болно гэж эрдэмтэд үзэж байна.

Далайн бусад нөөц баялаг

Далайн усны татралт, түрэлтийн хүч

Сарны татах хүчиний нөлөөгөөр далай, тэнгисийн усны түвшин хоногт хоёр удаа дээшилж, хоёр удаа доошилно. Үүнийг усны татралт, түрэлт гэж нэрлэнэ. Татралт түрэлт нь ялангуяа эгц эрэг бүхий газруудаар тод илэрнэ. Их хэмжээний ус түрэх татрах хүчийг ашиглан эрчим хүч ўйлдвэрлэх аргыг анх 1967 онд Франц улсад нээжээ. Үүнийг *турэлтийн усан цахилгаан* станц хэмээн нэрлэх бөгөөд дэлхий дээр ийм станц олон оронд байгуулан ашиглаж байна. Ялангуяа хүн ам цөөн, далайн усыг

Та үүнийг мэдэх үү?

Дэлхийн 1.4 тэрбум хүн чанарын шаардлага хангасан усаар дутагдаж байна.

Цөлжилтэд нэрзвэгдсэн, ус хомс зарим оронд далайн усыг цэнгэгшүүлэх замаар цэвэр усны асуудлыг шийдвэрлэж болно гэж үзэх нь ч бий. 12500 орчим газар ус цэнэгжсүүлэх ўйл ажиллагаа эрхэлж байгаа ч энэ нь дэлхийн цэвэр усны ўйлдвэрлэлийн дөнгөж 1%-ийг эзэлж байна.



ашиглахад хялбар газар буюу эргийн дагуух бүс орчимд ийм цахилгаан станц олон. Далайн түрэлтийн эрчим хүчний үйлдвэрлэлд ОХУ, Франц, Канад, АНУ, Япон зэрэг орнууд дэлхийд тэргүүлж байна. Гэвч атомын цахилгаан станцтай харьцуулахад түрэлтээс үйлдвэрлэж буй эрчим хүчний нийт хэмжээ төдийлөн их биш юм.

* Далайн усны давалгааны хүч

Далайн давалгаанаас үүсэж буй механик хүчийг усан дээр хөвөгч байрлуулах юм уу эсвэл ойролцоо эрэг дээр нь барилга байгууламж байгуулах замаар ашиглаж болдог. Япон, Хятад, Энэтхэг, Норвеги зэрэг оронд ийнхүү далайн усны давалгааны хүчийг ашигладаг. Энэ нь цэвэр эрчим хүчний үйлдвэрлэл боловч барилга байгууламж болон технологийн өртөг өндөр байдаг бэрхшээлтэй.

* Гидротермийн эх булаг

1977 онд Францын Сиана шумбагч онгоц Мексикийн эрэг орчим Номхон далайн 3000 метрийн гүнд 350°C температур бүхий гүний дулааны эх үүсвэрийг нээн илрүүлжээ. Үүний учир нь далайн ёроолын гүн хэсэг мантид орших тул халуун хайлмалмагмын нөлөө юм. Ийм халуун орчинд дасан зохицсон бичил биетэн ч олон бий. Гэвч эдгээр бичил биетэн зөвхөн нарнаас л ирдэг гэрлийн орчинг хэрхэн бий болгож байгааг хараахан судалж амжаагүй байна. Энэхүү гайхамшигийн нууц яваандаа тайлагдан, эдгээр бичил биетэн дэлхий дээр амьдрал үүссэн үйл явцыг танин мэдэхэд чухал үүрэг гүйцэтгэж ч мэдэх юм.

* Эм ба анагаах ухаан

Усны 200000 орчим төрөл, зүйлийн сээр нуруугүй амьтад (загас, нальхан хорхой гэх мэт), далайн замаг зэрэг нь хүн, амьтны бие махбодын бодисын солилцоонд чухал үүрэгтэй маш олон химийн бодисыг агуулж байдаг нь тогтоогдоод байна. Дөчөөд жилийн өмнөөс эдгээрийг эм бэлдмэл хийхэд хэрхэн ашиглах боломжийг судалж иржээ. Одоогоор бүрэн гүйцэд ашиглаж эхлээгүй ч усны амьтдын зарим нэг төрөл, зүйлийг өмөн хорт хавдрыг ангаахад ашиглаж эхлээд байна.

Усны биологийн төрөл зүйлийг анагаах ухааны салбарт ашиглах боломжийг судлах ажил маш өндөр өртөгтэй юм.



Эм зүйн
ухааны болон
биотехнологийн
салбарынхны
хувьд усны
биологийн
төрөл зүйлсийн
удмын сангийн
элементүүд
нь шинэ
бүтээгдэхүүн
үйлдвэрлэх эрдэм
шинжилгээний
ажлын гол
судлагдахуун
болж байна.

Хүний үйл ажиллагааны үр дагавар

* Далай эрэг орчмын хүн амын бөөгнөрөл

Дэлхийн хүн амын бараг тал орчим хувь нь далайн эрэг дагуу буюу 200 км-ийн зайд л оршин суудаг. Энэ тоо 2025 он гэхэд нийт хүн амын дөрөвний гуравтай тэнцэхүйц хэмжээнд хүрэх буюу дэлхийн хүн амын ихэнх нь эрэг орчмын бүсэд төвлөрөх тооцоо гарч байна. Энэ төвлөрөл нь өлсгөлөн, ядуурлыг улам нэмэгдүүлж, өдөрт 2 доллар хүрэхгүй орлоготой хүн амын тоо нэмэгдэх бодит аюул нүүрлэнэ хэмээн эрдэмтэд үзэж байна.

Хүн
торолхтоний
нийтийн
өмч болох
усан орчны
байгалийн
нөөцийг
ашиглаж буй
загасчдын тоо
40 саяд хүрээ.

Хэрвээ ийм олон хүн ам эрэг хавийн бүсэд амьдрахад хүрвэл тэдний амьдралын гол эх үүсвэр болох усны биологийн төрөл зүйлийн хомсдол ихдэн, усны бохирдлыг улам нэмэгдүүлэх нь гарцаагүй. Усны эх булгийн ойролцоо хүн ам, хот суурин, аж үйлдвэр төвлөрснөөс усны нөөц баялаг шавхагдахад хүргэх аюулаас сэргийлэх нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Дэлхий дааэр ядуурлыг бүүрүүлж, эдийн засгийн хувьд хэмнэлтийн амьдрах арга технологийг дэлгэрүүлэх, усан орчны нөөцийг хадгалан хамгаалан тогтвортой хөгжилд хүрэхийн түүлд эрэг хавийн оршин суурин дээрээс илүү наидвартай, эрүүл газар лүү нүүлгэн шилжүүлэхийг ЮНЕСКО-гоос санал болгож байна.

* Загас агнуур

Загас агнуур нь далайд гарцтай улс орнуудад хамгийн өргөн дэлгэрсэн эдийн засгийн салбар юм. Бие даасан салбар болохынхоо хувьд олон хүнийг (ялангуяа хөгжиж буй орнуудад) ажлын байраар хангах, хүнсний хэрэгцээг



хангах гэх мэт олон давуу талтай. Гэвч загас агнуурын томоохон бүсүүдэд загасны нөөц хомсдож, зарим зүйл нь устах аюулд хүрчээ. Эдгээр бүс нутагт жилд нийт 90 сая тонн загас авладаг нь хэт их тоо юм.

Нас гүйцээгүй болон үржлийн үедээ байгаа загасыг барих нь маш хараглан

үйлдэл билээ. Загасанд нөхөн үржих хугацаа хэрэгтэй. Загасчлалын уламжлалт арга хэрэгсэл, тоног төхөөрөмж хуучран загасыг тамлан зовоож байгаа талаар амьтан хамгаалагчдын зүгээс шүүмжлэл их гардаг. Далайн эрэг орчмоор ийм загасчлал их бөгөөд ихэнхдээ хууль бус ажээ. Ахуйн ба үйлдвэрийн хог хаягдлыг гол горхи, нуур цөөрөм, далай тэнгист хаяснаар усан орчинг бохирдуулж, загас болон усны бусад амьтдын нөхөн үржил буурах, тоо толгой хомсдох, биологи-экологийн хувьсал өөрчлөлтөнд өртөхөд хүргэж байна. Ялангуяа хөгжиж буй орнуудад зөвхөн ахуйн хэрэгцээгээ хангах, амьжиргаагаа залгах үүднээс усыг бараадан орших загасчдын тосгод усны бохирдол, чанар муудаход хамгийн их нөлөөлдөг.

Хүчин чадал ихтэй загас агнуурын аж ахуйг хөгжүүлэх нь арай дээр боловч жижиг аж ахуй эрхлэгчдийг амьжиргааны эх үүсвэргүй болгох талтай юм.

Дэлхий дээрх загас агнуурын гол бүс нутгийн нэг нь Хойд тэнгис ба Газрын Дундад тэнгис юм. Энд хэрэглэдэг доод хэсэгтээ хүндрүүлэгч, дээд талдаа хөвүүр бүхий олон километр урттай аварга тор нь усны гадаргуугаас доош ч олон арван метрийн гүнтэй тойрог үүсгэн, далайн давалгаа, усны урсгалаар туутдан ирсэн загасыг тонн тонноор нь барих хүчин чадалтай.

Балтийн тэнгис ч загас агнуурын гол цэг бөгөөд энд яргай загасыг 2 км-ийн урттай тор тавьж авладаг. Европын холбооны орнууд 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн өөрийн харьяаллын усанд тороор загас барихыг хоригложээ.

Ховордсон зарим төрөл, зүйлийг агнуурын загасны жагсаалтаас хасах нь хамгаалах сайн арга юм. Мөн зарим ашигтай төрөл зүйлийг байгалийн тархацад нь сөрөг нөлөө үзүүлэлгүйгээр өсгөн үржүүлэх нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх боломж олгодог. Жишээ нь: Манай оронд тул загасыг Улаан номонд

Та үүнийг мэдэх үү?

Өнөөдөр 4 сам хорхой тутмын 1, хясааны 80 хувийг усны аж ахуй хангаж байна.



Аварга том тор бүхий загасны үйлдвэрийн холюг онгоц нь хоногт дунджаар 1000 тонн загас авладаг. Энэ нь далайн загасны нөөц хэр зэрэг “хурдацтайгаар” хорогдож буйг гэрчилж байна.

оруулсан нь түүнийг хамгаалах чухал алхам болжээ.

*Загас нь хүн
төрөлхтөний
хүнсний
хэрэгцээг
хангах
байгалийн
чухал нөөцийн
нэг юм.*

Тор тавих аргаар загасчлах нь усны бусад амьтдад ч халгаатай. Загасны төронд орсон өөр жижиг загас, бусад амьтдын ашиглагдахгүй зарим нь үхсэн, гэмтсэн янз бүрийн байдалтайгаар усанд хаягддагийн дотор устах эрсдэлд ороод буй төрөл зүйлүүд ч багтана. Ийм байдалтайгаар жилд 27-35 сая тонн орчим ховор, нэн ховор, устаж буй болон ашиглагддагтгүй төрөл зүйл золиослогддог байна. Энэ нь нэг удаагийн загас агнуурын гуравны нэг нь хаягддаг гэсэн үг юм.



1970-аад онд загасчлал дээд цэгтээ хүрч, асар их сүйтгэл авч ирсэн бөгөөд ийм гамшигт дахин өртөхгүйн тулд НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн Байгууллагаас “загасчлалын завийн тоог дөрөвний нэгээр бууруулах” шийдвэр гаргажээ. Энэ нь загасны аж ахуйн тогтвортой хөгжлийг ханган, усны байгалийн нөөцийг хойч үеийнхэндээ өвлүүлэхэд чухал алхам болж байна. Зарим газар тодорхой хугацаанд загас агнуурын хориог тогтоох, барьсан загасны тодорхой хэмжээг усанд буцаан тавих журам зарим оронд бий. Жишээ нь: Исланд, Намиб, Норвеги, Шинэ Зеланд зэрэг оронд ийм туршлага бий. Энэ нь усны нөөц бага, загасны төрөл зүйл ховор манай орны хувьд дэлгэрүүлбэл зохих сайхан жишээ юм. Ялангуяа загасчид зөвхөн өөрийн хүссэн, авлах загасаа л барьдаг хэвшилд суралцах нь чухал.

* Эрэг орчмын хотжилт ба аялал жуулчлал

Дэлхийн томоохон хотуудын ихэнх нь далайн эрэг дагуух бүсэд оршино. Далайд гарцтай хөгжингүй болон хөгжиж буй орнуудад эрэг дагуух хотжилт асар хурдацтай нэмэгдэж байна. Жишээ нь: Өмнөд Европ буюу Газрын Дундад тэнгисийн хойд эрэг дагуу зуу гаруй км газар барилга байгууламжаар дүүрэн тэр хавийн байгалийг бүхэлд нь өөрчилжээ. Барилга байгууламж нь байгалийн эмзэг тогтолцоог доройтоход хүргэж хөрсний нуралт үүсэх, хөрс гулсах үзэгдэл их ашиглагдана. Том том бетонуудыг газарт суулган барилга байгууламж олноор барих нь далай тэнгис, нуур гол орчмын хөрсөнд суулт өгөхөд хүргэж байна. Иймд ялангуяа хөгжиж буй ядуу орнууд барилга барихаас өмнө урьдчилсан судалгаа хийхэд анхаарах ёстой. Гол, нуурын усанд



Францын эрэг дагуух усанд амьдардаг 350 зүйлийн загасны 14 нь устах аюулд өртөөд байна.

Загасны аж ахуй

1960-аад оноос хойши ялангуяа Азийн орчнүүдэг загасны аж ахуй хөгжлийк эхэлсэн бөгөөд загас төдийгүй нальхан хорхой, далайн замаг зэрэг бусад амьтдаг и үргжүүлэх болжээ. Загасны аж ахуй нь ашигтай загасны тохион үргжлийг нэмэгдүүлэн хүн амьян хэрэгжиээг далайн бүтээгдэхүүнээр хангах гол хэлбэр юм. Гол орлогодоо загасны аж ахуйгаас олдог үлс орон и дэлхийд олон. Тэхдээ энэ нь байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй. Түүний органыг бодис болон антибиотикоор баялаг хаягдал ус орчноо бохирдуулж, үргжүүлгийн онгоцны байгууламжкууд нь байгалийн үнаган төрхийг алдаагүүлдэг. Үүний үлмаас Мангровын үзэсгэлэнт байгаль эвдэгдэж, загасны аж ахуйн "үргжүүлгийн тасаг" болон хувирч байна.

ахуйн болон үйлдвэрийн хаягдал орсноос болж усны экосистемийн тэнцвэрт байдалд алдагддаг.

Эрэг орчмын аялал жуулчлал нь тэр хавийн төрх байдлыг ихээхэн өөрчилнө. Тухайлбал, эрэг дагуух элсийг ашиглан наран шарлагын газар байгуулах, зочид буудал болон үйлчилгээний бусад барилга байгууламж барих нь байгалийн экосистемд сөргөөр нөлөөлнө. Зөвхөн Газрын Дундад тэнгисийн эргийн бүсэд гэхэд л жил бур 100 сая жуулчин ирдэг бөгөөд тэднийг даган байнгын оршин суугчдын тоо ч өсөж байна. Хэрэв байдал хэвээр үргэлжилбэл 2025 он гэхэд энэ тоо 3-4 дахин өсөх ажээ. Аялал жуулчлал нь олон улс орны эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг салбар боловч нөгөө талаас далай, тэнгисийн ус болон эрэг орчмын газруудад маш сөрөг

Та үүнийг мэдэх үү?

Дэлхийн жуулчдын гуравны нэгийг Газрын Дундад тэнгисийн бүсэд ногдоно.

нөлөөтэй. Аль ч оронд аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ байгалийн үзэсгэлэнт төрх байдалд түшиглэдэг тул хажуугаар нь байгалиа хамгаалахад төр засаг, хувийн хэвшлийнхэн, иргэд анхаарах туйлын зөв юм.

Торнадо, цунами, хар салхи зэрэг байгалийн гамшигт үзэгдэл далайн эрэг хавиар тохиолдох нь олонтаа. Байгалийн гамшигт өртөх магадлал ихтэй эрэг орчмын бүс нутагт урьдчилан сэргийлэх болон гамшигийн үеийн арга хэмжээ авахын тулд ажиглалт, судалгаа шинжилгээ хийхэд “Засгийн газар хоорондын далај судлалын зөвлөл” ихээхэн үүрэг гүйцэтгэж байна.

Гол мөрөн дээр далан босгох, гол сав газраас мод бэлдэх, тариалан эрхлэхийн тулд ширэнгэн ойг тайрах зэргээр эмзэг нарийн зохилдлого бүхий усны экосистемийг доройтуулах шалтгааныг зөвхөн хүмүүс бил л үйлддэг.

2006 оны
12 сард
Энэтхэгийн
далайд үүссэн
циунамийн
нөлөөгөөр
Зүүн Өмнөд
Азийн олон
орон ихээхэн
хохирол амссан
бүлээ. Энэхүү
аймшигт
үзэгдлээс хойш
Филиппин,
Тайланд, Япон,
Шри Ланка
зэрэг оронд
циунамаас
урьдчилан
сэргийлэх
зорилгоор
усны гүнийг
хэмжих,
газрын
чичирхийллийн
болон зайнлас
тандан судлах
станцыг
олноор
байгуулжээ.





Та үүнийг
мэдэх үү?

Дэлхийн
нийт загасны
хэрэгцээний
70%-ийг
зөвхөн 10 улс
л хангадаг
байна.

Далай тэнгисийн эргээр хүн амын нягтишил их байдаг. Учир нь амьдрахад таатай уур амьсгал, үзэсгэлэнт байгаль болон хүнсний нөөцөөр элбэг дэлбэг газар лхүмүүс оршин суух дуртай. Гэвч усны экосистемийн эдгээр баялаг нөөцийг ашиглах явцдаа бохирдуулж, нөөцийг нь хомсдуулж байгаа нь байгалийн өвөрмөц тогтолцоог аюулд учруулж байна гэсэн үг юм.

Далай, үснээ эргийг хамгаалах хөтөлбөр

Гүехэн үстмий эргийн бүс нь далайн экологиг чухал үүрэгтэй. Энд газрлан тос зэрэг ашигт мэтмал, байгалийн нөөц, элбэг, далайн амьтдын хоол тэжээл болохуйц эргэс бодисоор баялаг тул өсөн үржих таатай орчин болдог. Иймд 1997 онд "Засийн газар хоорондлан далай сүдлэлийн зөвлөл"-өөс далайн эргийн орчин ба эрэг хавийн үйл ажиллагааныа менежментийн хөтөлбөр боловсруулжээ. Энэ хөтөлбөрийн зорилго нь:

- Далайн эргийн усан орчинд ажилалт сүдалгааг өргөтгөх
- Эрэг орчины экосистемэд тулгамдаж бүй асуудлыг шийдвэрлэх талаар мэдээлэл, түршлэгээ солигох
- Орон нутгийн зүгээс авах арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

2002 онд Өмнөд Африкийн Кохансбург хотноо болсон "Тогтвортой хөгжлийн" ийн талаарх олон улсын хуралдааны тэрзүүлэх зорилт нь эргийн орчинд хамгаалалтанд авах тухай асуудал байлаа.




Далай ба усны бохирдол

* *Бохирдлын эх үүсвэрүүд*

Далайн уудам орон зай бүх л хог хаягдлыг төвөггүй шингээх чадвартай юм шиг саяхныг хүртэл үзэж байв. Гэвч тийм бишээр зогсохгүй хог хаягдаас болж байгалийн тэнцвэрт байдал алдагдах хэмжээнд хүрээд байна. Хамгийн ойрхны жишээ дурдахад л Газрын Дундад тэнгисид хар давалгаа үүсэх, хаг замгаар бүрхэгдэх нь улам ч ихэссээр байгаа бөгөөд биологийн төрөл зүйлсийн хомсдол зэрэг олон сөрөг үр дагаварын гол шалтгаан нь усны бохирдол гэдгийг хэн хүнгүй мэднэ.

Далайн бохирдлын 70 орчим хувь нь хуурай газрын гаралтай аж. Эдгээр нь ус цэвэршүүлэх байгууламж, үйлдвэрийн хаягдал, химиин бодис ба тэдгээрийн нэгдэл, хуванцар эдлэл, өтөг бууц болон нянгийн эсрэг хэрэглэдэг химиийн бүтээгдэхүүн зэргээс үүдэлтэй юм. Жишээ нь: тариалангийн талбайн хөрсийг бордсон химиин бодис нь хөрс шороонд шингэх, агаарт дэгдэн хур тунадастай хамт буух замаар гол мөрөн, нуур цөөрөм, далай тэнгисийн усыг бохирдуулдаг.

Усан тээвэр ч бохирдолд бүр нэрмээс болно. Ялангуяа газрын тос тээвэрлэгч том хөлөг онгоц сүйрэх үед далай тэнгисийн усны бохирдол аюулын хэмжээнд хүрч, амьтдыг олноор нь үхэлд хүргэдэг. Жишээ нь: Эрика болон Престиж хөлөг онгоцыг дурдаж болно. Манайд ч гол, нууранд машин тэрэг живэх тохиолдол гардаг. Хөвсгөл ба Увс нуурын ёроолд живсэн машинуудын зарим нь одоо ч тэндээ үлдсэн гэдэг. Алдартай наран шаралгын газрууд ч бохирдож, өд сөд нь бүрзийж өнгө нь ялгагдахаа больсон шувууд, хүнсэнд ашиглаж болохгүй болтол хордсон загас, хясаа... Энэ бүхэн бохирдлын ул мөр болно.



Усан орчныг хамгаалах хөтөлбөр

1995 онд НҮБ болон Европын холбоо "Бохирдож буй усан орчныг хамгаалах дэлхий нийтийн хөдөлгөөн" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлжээ.


Энэ хөтөлбөрөөр Усан орчинд нүүрлээг буй хуурай газраас улбаатай бохирдлын эх үүсвэрүүдийг бүүрүүлахад оныгой анхаарахыг бүх үлс оронд үриалсан билээ. Үүний тулд:

- Техникийн нөхцлийг сайжруулах
- Үйлдвэрийн хаягдалг хяналт тавих, зарим газар хог хаягдлын хязгаарыг тогтоох (жишиг нь: Франц, Их Британи зэрэг оронд)
- Эрдэс бордоо, отөг бүүч ашигладаг газар үс цэвэршигүүлэх байгууламж барих зэрэг аргуудыг нэвтрүүлээг байна.


Түүнчилэн жилээс жилд осон нэмэгдэж буй эрэг хавийн төвлөрлийг саарууллах, тэр дундаа экологийн даанаг тохирсон газар зохион байгууламж газар ашиглалтын хэлбэрүүдийг шинэчилэх ажил нэн шаардлагатай болоог байгааг анхааруулсан байна.

Байгалийн бохирдлын эх үүсвэрийн ихэнх нь бидний үйл ажиллагаанаас гаралтай юм. Аяга угаах шингэн, угаалгын нунтаг хэрэглэх зэрэг өдөр тутмын амьдралаас эхлээд газар тариалан эрхлэх, ой мод бэлтгэх явцад бохирдуулагч бодис үргэлж л ялгарч байдаг.

Газрын тос олборлох зэрэг хүнд аж үйлдвэрийн хог хаягдал усанд орох нь нэн аюултай. Харамсалтай нь газрын тос үйлдвэрлэгчид зөвхөн ашгийн хойноос хөөцөлдөж, "хийн шахалт" гэж нэрлэгдсэн агуулах суллах үйл ажиллагаа явуулдаг нь далай тэнгисийн усыг маш ихээр бохирдуулдаг. Үүнийг хориглох хууль дүрэм гарсан ч нууцаар зөрчсөөр байна. Жилд ойролцоогоор 600000 тонн орчим нүүрс-усстөрөгч болон түүний нэгдэл болох химийн хог хаягдал усанд хаягдаж байна. Эдгээр нэгдлүүдийн ихэнх нь усанд маш муу уусдаг учир ёроолд тунаж үлддэг. Түүнчлэн уул уурхайн салбарт хэрэглэж буй мөнгөн ус, цианид зэрэг хортой нэгдлүүдээс болж усны экологид хор хөнөөл учирч байна.



Зарим хаягдлын үсанс хадгалалцах хүзүүлэлт



Дээр дурдсан газрын тос, мөнгөн ус, цианид зэргээс гадна усыг бохирдуулагч бусад бодисыг тоочихын аргагүй. Ялангуяа үйлдвэрлэл хөгжсөн ч хууль эрхзүйн орчин нь төдийлөн бэхжээгүй Африк, Өмнөд Америкийн зарим оронд усны бохирдол бүр ч их юм. Монгол орон хэдийгээр далайгаас алслагдсан боловч зэлүүд, газар хаясан хог хаягдал ч газрын хөрсөнд шингэн гүний усны нөөц, урсгал усны чанарт сөрөг нөлөөлдөг.

Та үүнийг мэдэх үү?

Далайд хаягдсан хорт бодисын 90% нь хүн олноор суурьшсан, баялгийг нь илүүтэй ашиглах эргийн бүс нутгаас гаралтай.

* Усны бохирдлын хор уршиг

Бохирдуулагч бодисууд зөвхөн байгаль орчинд нөлөөлөөд зогсохгүй улмаар хүн, нийгмийн амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ. Жишээ нь: хортон шавж устгадаг “ДДТ” зэрэг нэгдэл усанд олон жилээр хадгалагдан, ургамал амархан хатаж гандах, хүн амьтныг халдварт өвчинд тэсвэр муутай, өвчлөмтгий болгодог. Газар тариаланд ашигладаг эрдэс бордоо, өтөг бууц нь далайн зарим замаг хаг, хигдэрийн нянгуудын өсөлт, хөгжилтийг түргэсгэнэ. Замаг хэт хурдан өссөнөөс хоромхон зуур усны мандал дээр 1-2 метрийн зузаантай хивс мэт ногоон ширэг үүсэн хүчилтөрөгчийг маш ихээр хэрэглэнэ. Энэ нь загас, хясаа зэрэг усны амьтад хүчилтөрөгчөөр дутагдан өсөлт үржил нь муудах үндэс болно. Балтийн тэнгист 70000 km^2 талбайд бүх амьтад устан угүй болсон нь үүний нэг тод жишээ юм. Манай говь нутагт өвөрмөц тогтоцтой Эрээн нуур, Сүхбаатар аймгийн Ганга нуур зэргийн хөвөө замагт хучигдан амьд организм амьдрах боломжгүй төвшинд хүрээд байна. Замаг ихсэх нь байгалийн узэмжийг бууруулаад зогсохгүй, хүнсний хэрэгцээний

тодорхой хэсгийг хангах загас, усны гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг хомсдуулж байгаа хэрэг юм.

* Ус бол хун төрөлхтөний амьдралын үндэс

Усны бохирдол нь улмаар бидний амьдралын орчинг доройтуулж, амьдралын чанарыг муутгана. Бохир усанд хордсон загас, дун хясаа зэрэг далайн гаралтай хоол хүнс хэрэглэснээс өвчин эмгэг үүсэх, эмчилгээнд мөнгө зарцуулах замаар амьдралд нөлөөлно.

Латин Америк, Газрын Дундад тэнгис, Зүүн өмнөд Азийн олон оронд эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнс хэрэглэснээс болж үүсэх холер өвчний халдварт голомт бий болжээ. Бохирдсон усанд орсноос ч халдварт авна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын тооцоолсноор жил бүр 250000 орчим хүн бохир ус хэрэглэснээс болж хоол боловсруулах эрхтний үрэвсэл болон амьсгалын замын өвчнөөр өвчилдөг аж. Харин далайн усанд сэлэх, эрэг дээр нь амрах 20 хүн тутмын нэг нь өвчлөх эрсдэлэйд тооцогддог.

Та үүнийг
мэдэх үү?

Дэлхий дээр
усан тээврээр
жилд 1 сая тонн
газрын тос
тээвэрлэдэг.



Далайн үсан дахь хуванцар хаягдал

Жил бүр хадэн зүүн төнн хамгуу хог хаягдал эрзээс олон зүүн километрийн алсаад үсан даар хөвөх болсоор үдааж байна. Гол мөрний таавэр болон далайн хөлөг онгоцноос ялгарах хаягдлын хэмжээ үлам бүр нэмэгдсээр байна. Эдгээр хаягдлын зурагбны хоёр нь хуванцар эзлэл байгааг аж. Хамгуу хог хаягдал маш удаан хүгэцааанг хадгалалгдан хол заид хөвдөг тул хүри экосистемд үзүүлэх сөрөг нөлөө нэн их. Жишээ нь: Гялгар үүт идсэнээс яст мэлхий, далайн хав болон май загас зэрэг амьсгал нь боогдох үхэхэг хүрнэ.

Тогтвортой хөгжил

Тогтвортой хөгжил гэж юу вэ?

Тогтвортой хөгжил гэж өнөөгийн хүн төрөлхтний хэрэгцээг хангахдаа байгалийн тэнцвэрт байдлыг хангах, усны чанарыг нэмэгдүүлэх, хүн амын эдийн засгийн ялгавартай байдлыг бууруулах, амьдралын зүй зохистой хэв маяг, хэрэглээг бий болгох зэрэг зарчмуудыг мөрдөж, ирээдүй хойч үеийнхний хэрэгцээг эрсдүүлэхгүйгээр хөгжих арга замыг хэлнэ.

Тогтвортой хөгжилд хүрэхийн тулд 2005-2014 оныг НҮБ-аас “Тогтвортой хөгжлийн 10 жил” хэмээн зарлан тунхагласан билээ.

* Түүхийн товчоон

1987. НҮБ-ын дэргэд Брунландын зөвлөл тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг анхлан тодорхойлсон байна.
1992. Бразилийн Рио-де-Жанейро хотод болсон Дэлхийн



Байшинг байрнаас хөндийрүүлэхгүй хүчинтэй хар шүүрэгээ нь Эл өндоо идэвхжксэнээс болж үүснээ (Гондурас үлсэд).



Мадагаскар наан
Нози Ба дахь
далай судлалын
үндэсний төв.

дээд хэмжээний уулзалтанд (“Байгаль орчин ба хөгжил” сэдэвт Нэгдсэн Үндэстний Байгууллагын бага хурал) 178 орон оролцож хүн төрөхтний өмнө тулгамдаад буй гол асуудал болох “Өнөөдөр болон ирээдүй хойч үед тулгараад буй гачигдлыг хэрхэн шийдвэрлэх вэ?” гэдэгт гол анхаарлаа хандуулсан юм. Хурлын явцад олон тооны баримт, сурвалж мэдээнд тулгуурлан дэлхийн байгаль экологид гарч буй хувьсал өөрчлөлтийн талаарх илтгэлүүдийг хэлэлцэн “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр-21”-ийг баталсан нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд ээрэг үр нөлөөг үзүүлсэн томоохон алхам болсон юм.

- 2002.** Өмнөд Африкийн Иоханесбург хотноо болсон “Тогтвортой хөгжил” сэдэвт НҮБ-ын дээд хэмжээний чуулга уулзалтад 129 орны төрийн тэргүүн, 60000 гаруй элч төлөөлөгч оролцжээ. Энэхүү уулзалтаар “Хөгжлийн хөтөлбөр-21”-ийн хэрэгжилт, үр дүнг хэлэлцэн хөгжингүй орнуудын экологийн доройтлыг нөхөн сэргээхийн тулд агаарт ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээг арван жилийн дараа гэхэд 5.2 хувиар бууруулах зорилт тавьжээ.
- 2009.** Дани улсын нийслэл Копенгаген хотноо дэлхийн бүх улс орны төрийн тэргүүн уулзаж уур амьсгалын дулаараг, түүнээс гарах сөрөг үр дагавар, багасгах арга замын талаар хэлэлцэв.

Та үүнийг мэдэх үү?

Газрын тос
тээвэрлэгч том
хөлөг онгоц
нь 400000
л хүртэл
багтаамжтай.

* “Үйл ажиллагаа - 21” хөтөлбөрийн 17-р зүйл

Тогтвортой хөгжил ба ядуурлыг бууруулахад тус дөхөм болох нэг алхам бол далай ба эрэг хавийн орчныг зүй зохицтой ашиглан хамгаалах явдал юм. “Хөгжлийн хөтөлбөр-21”-д далай тэнгисийн асуудлыг тусгай зүйл болгон оруулсан нь ч үүнтэй холбоотой юм. Далайн орчин эрүүл байх нь зөвхөн амьтад төдийгүй дэлхийн уур амьсгалын тэнцвэрт байдлыг ханган, хүний нийгэм, эдийн засаг, соёл оршин тогтоноход ч чухал үүрэгтэй. Иймээс далайн усны бохирдлыг бууруулах, дорийтлыг нөхөн сэргээхийн тулд шинжлэх ухааны мэдлэгт тулгуурласан хамгаалах арга хэмжээг авах нь зүйтэй юм.

Та үүнийг мэдэх үү?

1970 -aad оны үеэс дэлхийн өнцөг булан бүрт хотжих үйл явц эрчимжиж, орчны бохирдол ч нэмэгдсэн билээ.

Яланугяа хүнд үйлдвэрүүд эргийн бүс нутгүүдад шилжин байршил болсноор наран шарлагын газрууд бохирдолд орж зарим нь сүйрлийн ирмэгт хүрээд байна.

Далайн олон үлсийн жил

Нэгдсэн Ундастний Байгууллага 1998 онд “Далайн олон үлсийн жил” хэмээн түнхагласан нь далай, тэнзис болон үсан орчны талаарх мэдээллийг нийгмийн амьдралын бүхий л ёе шатанд, соёл, үлс төр, эдийн засгийн үйл ажиллагаанд таниулахад томоохон алхам болкээ. Энэ ажлын хүрээнд гаргасан түнхажт дэлхийн олон орчны сая сая иргэд нэгдэн гарын үсгээ зурсан бөгөөд далай тэнгисийн хувьс түүлгэрийн асуудлыг шийдвэрлэх зөвлөл байгууллагдан ажиллаж олон хөтөлбөр хэрэгжүүлжээ.

* ЮНЕСКО-гийн үйл ажиллагаа

НҮБ-ын Олон Улсын Хөтөлбөр нь далай судлалаар мэргэшсэн байгууллага бөгөөд ЮНЕСКО-той хамтран далайн тогтвортой хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг. Гэвч ганц байгууллага бүхнийг дангаараа хийх боломжгүй тул НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагууд, олон улсын эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лабораториудтай хамтран ажилласаар иржээ.

Энэ хүрээнд уур амьсгалын урт хугацааны хэлбэлзлийг тодорхойлох; ус судлалын олон улсын тогтолцоог байгуулах; усан мандалтай холбоотой мэдээллийг нийтэд түгээх, солилцох үйл явцыг сайжруулах; далайн эрэг хавийн бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх; усан мандлын хөгжлийн талаар шилдэг мэдлэгийг хурилтуулах; усан орчинд үзүүлж буй хүний

ажиллагааны үр нөлөөг тодорхойлох; судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг, нэн ялангуяа буурай хөгжилтэй орнуудад эрчимжүүлэх, боловсон хүчнийг чадавхиуулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Олон Улсын Усзүйн Хөтөлбөрийн “Засгийн газар хоорондын зөвлөл” нь ирэх жилүүдэд шийдвэр гаргах төвшинд нөлөөлөгч гол хүчин зүйл болох шинжлэх ухааны судалгаа, туршилтын ажилд тулгуурласан мэдлэгийг бүрдүүлэх ажилд хүчин чармайлт гаргахад анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна. Үүнээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлж усан мандал, түүнийг далай, тэнгис, нуур, гол мөрнийг хамгаалахын ач холбогдлыг олон нийтэд таниулахад түлхүү анхааран ажиллах болно хэмээн үзжээ.“

Бидний амьдарч буй гариг дэлхийн байгаль орчны зайлшгүй шаардлагатай элемент болох ус нь шавхагдашгүй мэт боловч маш эмзэг бодис юм. Далай, тэнгис, нуур цөөрөм, гол мөрөн нь сая сая жилийн турш олон төрлийн амьд биетийн амьдралын орчин болсоор иржээ. Бид өөрсдөө усан мандлын орчин, түүний экологийн талаарх мэдлэг дутмагаас энэхүү агуу боловч эмзэг бүрхэвчийг устган үгүй хийлгүй харин ч эсрэгээрээ түүнд анхаарал халамж тавьж, нөхөн сэргээх хэрэгтэй юм” (“Тогтвортой хөгжил” Дээд хэмжээний чуулга уулзалт (2002)-аас

Та үүнийг мэдэх үү?

35000 загасны аж ахуйн нэгж далаин орчинд үйл ажиллагаа явуулж байна.

Хойд тэнгисийн загасны 20% нь үйлдвэрийн бохирдлын хаягдалд хордон ашиглах боломжгүй болжээ.



Цаасны үйлдвэр нь үсэгээ хамгийн гол бохирдуулаж юм.

Засцийн газар хоорондын зөвлөл

ОУУХ-ийн Засцийн газар хоорондын зөвлөл нь 1975 онд ЮНЕСКО-ийн дэмжклэсээр үснэг мандралын тэнцвэртэй байдалг нөлөөлөх сөрөг үйл ажиллагаа, хүчин зүйлсийг буургулахад холбогдох засцийн газруудад дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн үйл ажиллагааг низлүүлэн ажиллах зорилготойгоор байгуулагдсан.

Засцийн газар хоорондын зөвлөл нь энэ үүрээ:

- Техник технологи болон мэдлэг мэдээлэллийг нийтийн хүртээл болгох
- Олон нийтэд чиглэсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хэрэгжүүлж байна.

Үйл ажиллагаагаа явууллахдаа түхайн үлсдэг түлгарааг байгаа үснэг асуултуудыг шийдвэрлэхэд хүн бүрийн оролцоог хангахын түлд үлс орниа хөгжлийн нийтийг нэмэгдүүлэх, бусад үлс орнуудтай эрх тэшиг харилцаатай байх, холбогдох санхүүжилтийг низлүүлэхийг эрхэмлэдэг болно.

1999 оноос хойши Засцийн газар хоорондын далай судлалын зөвлөл 129 үлсээг өөртөө элсүүлснээр түүний байр суурь шинэ түвшингээ гарын ирээд байна. Эдгээр үлсүүг нь бүрдэг чүүлгэнд өөрийн суудалтай бөгөөд 2 жилийн түтмамд хуралддаг байна.



Далайн
бохирдсон
үснэг амьдрал
цахвэрээс бүрэн
алдагдаж амьтад
байдал. Жишээ
нь цэнхэр хөлт
нүзгэс сүүлийн
жилүүдээг
үнэгэн нүмэг
Эквадорын
Галапагос
болон Плата
арал дээр
озн үзэгдэхээ
больсон байна.



гаргасан Засгийн Газар хоорондын далай судлалын зөвлөлийн “Нэг дэлхий нэг далай” уриалгын дүгнэлт).

2001 оны 12 сард болсон далай болон түүний эрэг хавийн бүсүүдийн тогтвортой хөгжлийн асуудалд чиглэсэн олон улсын хурлаар улс орнуудын ерөнхийлөгчид хамтран: “Бид далай, түүний эрэг хавийн орнуудын эрүүл орчныг хангах үүрэг хариуцлагыг хүлээх онцгой шалтгаан байна. Хуралд оролцогчид, бид далайн орчинд нүүрлээд байгаа хүндрэлүүдийг бүрэн дүүрэн ойлгохын сацуу олон улсын байгууллагууд, төр засгууд нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байдал үүсээд байна” хэмээн уриалсан байна.

Байгаль орчинд үүсэж буй экологийн таажүй нөхцөл байдал, тэдгээрийн нийлбэр үр даваавар болох үүр амьсгалын өөрчилэлт нь бидний далайг үзүүлэж буй сөрөг нөлөөллийн хариу үйлдвэл юм.

Та үүнийг мэдэх үү?

Манай гариг дээр оршин буй 10 гаруй сая төрөл зүйлээс зөвхөн 1.5 сая нь л бүрэн тодорхойлогдоод байна.

Далайн 2500 метрээс доош 2500 метрээс зурагт хүчинтөрөгийн агууламж болга, нарны гэрэл хүргээгүй боловч орчинь төмөр замаар нилээд өндөр байдаг. Үснээ түвшинг альдардаг хавч, аварга биет нялцгай биетнүүд нь орчинь энэ таажүй нөхцөлбөй ид шидийн мөн арга хэлбэрээр дасан зохицониаг түн саяхнаас олж мэдсэн юм.

Энэ экосистем нь маш өвөрмөц, онцлогтой бөгөөд бидний таньж амжаацүй олон тохиол төрөл зүйлийг агуулдаг билээ.

Үгсийн тайлбар

Антициклон буюу эсрэгциклон: Агаарын өндөр даралтын муж.

Атмосфер: Хийн мандал буюу дэлхийн бөмбөрцгийн гадна талаар хүрээлэн орших хийн бүрхэвч.

Атом: Химийн элементийг бүрдүүлэгч хамгийн жижиг хэсэг.

Бактери буюу нян: Өвчин үүсгэгч нэг эст бичил биет. Амьд организмын исэж муудах үйл явцад оролцдох ба ямар нэгэн амьд бие махбодийн бий болгосон шим бодисоор хооллодог. Зарим төрлийн бактераар дамжин хүн, амьтанд халдварт өвчин тарна.

Сав газар: Гол мөрөн, нуур, далайн ай сав. Ай савууд нь ус хагалбараар зааглагдана. Ай савд орсон хуртунаас, бүх гол горхи тухайн ай савын үндсэн гол ба нуур, эсвэл далайд цутгана.

Түйлын мөстлөг: Дэлхийн өмнөд ба хойд туйл орчимд их хэмжээний талбайг хамарсан, он удаан жил хадгалагдан тогтсон мөсний масс. Жишээ нь: Антарктидийн эх газар ба Гренланд арлын ихэнх хэсэг мөсөөр хучигджээ.

Далайн аварга биет хөхтний бүлэг: Халим, далайн гахай гэх мэт усанд амьдарч уушгиар амьсгалдаг амьтдын бүлэг.

Идэш тэжээлийн хэлхээ: Ургамал болон бичил биетэнээс эхлээд жижиг амьтадаар дамжин үүсэх амьтдын хоол тэжээлийн гинжин хэлхээ. Амьтан бүр өөрийн идэш тэжээлээ олж идэхээс гадна өөрөө бусдын идэш тэжээл болдог. Жишээ нь: эгэл биетүүд жижиг загасны хоол тэжээл болдог бол жижиг загаснууд аварга загас, хөхтөн амьтдын хоол тэжээл болдог.

Экосистем: Амьд биетүүд ба тэдгээрийн амьдралын орчин, бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан холбоо бүхий цогц нэгдэл.

Эдийн засаг: Хүн өөрийн бодит хэрэгцээг хамгийн өндөр түвшинд хангах эсвэл оюун санааны таашаал эдлэх зорилгоор шууд ба шууд бусаар баялгийг (эд материал, үйлчилгээ) ашиглах үйл ажиллагаа.

Энергий: Материйн бүх төрлийн хөдөлгөөн болон харилцан үйлчлэлийн нийт тоо хэмжээ. Энэрги нь механик, химийн, эрчим хүчний гэхчлэн ангилагдана.

Элэгдэл, өгөршил: Ус, салхины үйл ажиллагаагаар уулын чулуулаг, өгөршин эвлээрч, зөөгдөж хуримтлагдах үйл явц.

Нүүрс-устэрөгч: Нүүрстөрөгчийн атом ба устэрөгчийн атомаас бүрдэх химийн нэгдэл. Нэгдэл дэх нүүрстөрөгчийн хэмжээнээс хамааран газрын тос болон шатагч хийг үүсгэнэ.

Органик бодис: Байгалийн гаралтай, амархан задарч үгүй болдог бодисын нэгдэл.

Планктон буюу хөвмөл: Далай тэнгси болон хуурай газрын усанд хөвөгч жижиг ургамал, амьтад. Жижиг бичил биетэн, замаг, хавч, нялцгай биетэн гэхчлэн олон төрөл бөгөөд ихэнх нь энгийн нүдэнд харагдахааргүй жижигтгэн, том амьтдын гол хоол тэжээл болдог. Хөвмөл амьтад буюу зоопланктон (тухайлбал бичил хавч хэлбэртэн), хөвмөл ургамал буюу фитопланктон (бичил замаг, хигдэр гэх мэт) хэмээн ангилна.

Биологийн нөөц: Амьд биет, ургамал, амьтны нийт нөөц.

Агуулга

<i>Усны шинж чанар</i>	2
<i>Цэнхэр нүдэн гариг</i>	4
<i>Далай тэнгис</i>	7
<i>Усны амьтан ургамал</i>	15
<i>Эрсдэлд орсон амьтан ургамлын төрөл зүйл</i>	18
<i>Усан мандлын нөөц баялаг</i>	21
<i>Далайн бусад нөөц баялаг</i>	23
<i>Хүний үйл ажиллагааны үр дагавар</i>	26
<i>Далай ба усны бохирдол</i>	32
<i>Тогтвортой хөгжил</i>	36
<i>Үгсийн тайлбар</i>	46

Хэрэгтэй хаяг

ЮНЕСКО

Парис хот 75352, Фонтеной талбай 7

Вэб хаягууд

ЮНЕСКО

<http://www.unesco.org>

Засгийн газар хоорондын далай судлалын зөвлөл

<http://www.ioc.unesco.org/iocweb/default.htm>

**Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж буй загвар төслүүдийг
удирдан чиглүүлдэг тус байгууллагын үйл ажиллагааг дэмжин,
сурталчилдаг олон мянган боловсролын байгууллагуудыг өөртөө
элсүүлсэн ЮНЕСКО-гийн хамтрагч сургуулиудын тогтолцоо**

<http://www.unesco.org/education/asp>

Францын далай ашиглалтын судлагааны эрдэм шинжилгээний

хүрээлэн

<http://www.ifremer.fr/francais/>

Европын байгаль орчны агентлаг

<http://www.eea.eu.int>



© Éditions UNESCO
1, rue Miollis – 75015 Paris

© Nouvelle Arche de Noé Éditions
153, boulevard Haussmann – 75008 Paris

ISBN 92-3-203872-2

A standard linear barcode representing the ISBN number 92-3-203872-2.

9 789232 038722

